

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026. 02. 25 № 103

танай _____-ны № _____-т

Г АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журмын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд түлш халаалтын зардалд 50,000,000 төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 13,100,000 төгрөгийг ахуйн үйлчилгээний халаалтын зардалд буюу үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зарцуулсан;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.38 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.18 15.2.1 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын хөтөлбөрийн хүрээнд үндсэн 7 арга хэмжээг хэрэгжүүлэх 1,539,566.7 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 85.1 хувь буюу 1,310,590.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 182,328.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 58 арга хэмжээг 100 хувь, 3 арга хэмжээг 70 хувь, 1 арга хэмжээг 60 хувь биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 98 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>93,853,387.00</u>	<u>106,731,368.00</u>
33	АВЛАГА	-	4,480,000.00
335	Бусад авлага	-	4,480,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	4,480,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	93,853,387.00	102,251,368.00
351	Түүхий эд материал	-	75,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	75,000.00
354	Хангамжийн материал	81,153,387.00	89,476,368.00
35420	Аж ахуйн материал	43,553,368.00	49,400,368.00
35470	Бусад хангамжийн материал	37,600,019.00	40,076,000.00
35600	Мал амьтад	12,700,000.00	12,700,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,026,124,666.05</u>	<u>1,984,872,538.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,026,124,666.05	1,984,872,538.94
392	Биет хөрөнгө	2,006,728,666.05	1,965,476,538.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	461,774,022.56	811,774,022.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(108,856,058.37)	(135,335,112.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	340,556,749.33	340,556,749.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(54,635,107.13)	(107,300,776.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,034,001.93	157,824,001.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,645,179.10)	(86,741,018.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,846,000.00	22,186,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,739,779.42)	(17,203,822.37)
39209	Зам, гүрийн байгууламж	246,752,486.00	172,819,699.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(99,655,868.49)	(56,600,087.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,083,555,824.00	1,231,190,259.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(209,239,437.26)	(367,693,376.08)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	242,981,012.00	-
393	Биет бус хөрөнгө	19,396,000.00	19,396,000.00
39301	Программ хангамж	4,200,000.00	4,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,200,000.00)	(4,200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,396,000.00	19,396,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,119,978,053.05</u>	<u>2,091,603,906.94</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,466,880.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,466,880.00
413	Өглөг	-	3,466,880.00
4136	Бусад өглөг	-	3,466,880.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,466,880.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,119,978,053.05</u>	<u>2,088,137,026.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,119,978,053.05	2,088,137,026.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	320,106,269.20	320,106,269.20

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	320,106,269.20	320,106,269.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,679,484,922.27	1,647,643,896.16
51210	Өмнөх үеийн үр дүн	1,679,484,922.27	1,679,484,922.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	(31,841,026.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,386,861.58	120,386,861.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,119,978,053.05</u>	<u>2,091,603,906.94</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,573,657,961.00	1,426,842,213.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,573,657,961.00	1,426,842,213.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,546,761.00	12,596,763.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,496,761.00	3,055,763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,541,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,566,111,200.00	1,414,245,450.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,566,111,200.00	1,414,245,450.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,644,502,160.45	1,741,499,169.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,644,502,160.45	1,741,499,169.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,382,214,520.45	1,542,670,229.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,088,000.00	717,571,565.58
210101	Үндсэн цалин	383,136,342.50	434,406,388.38
210102	Нэмэгдэл	199,074,232.50	269,111,505.25
210104	Урамшуулал	25,877,425.00	14,053,671.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,011,000.00	89,819,600.00
210201	Тэтгэврийн даатгал	51,687,400.00	61,077,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,080,900.00	7,185,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,864,700.00	3,592,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,200.00	3,592,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,161,800.00	14,371,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,000,000.00	48,191,593.00
210301	Гэрэл, цахилгаан	17,000,000.00	25,091,593.00
210302	Түлш, халаалт	40,000,000.00	23,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,777,000.00	54,034,640.00
210401	Бичиг хэрэг	9,000,000.00	6,831,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,050,000.00	30,057,896.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	6,054,744.00
210404	Ном, хэвлэл	1,900,000.00	801,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,088,000.00	8,289,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,739,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,262,800.00	38,344,400.00
210604	Урсгал засвар	37,262,800.00	38,344,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	8,000,000.00

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,533,745.00	118,417,462.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	223,133,745.00	117,589,224.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	135,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	143,178.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	301,041,975.45	468,290,969.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,705,400.00	116,102,819.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	209,336,575.45	352,188,150.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	262,287,640.00	198,828,939.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,076,110.00	16,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	58,076,110.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	204,211,530.00	182,328,939.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	204,211,530.00	182,328,939.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(70,844,199.45)	(314,656,956.11)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	95,199,999.96	42,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	95,199,999.96	42,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(95,199,999.96)	(42,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(166,044,199.41)	(356,656,956.11)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,573,657,961.00	1,426,842,213.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,573,657,961.00	1,426,842,213.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,546,761.00	12,596,763.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,496,761.00	3,055,763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,541,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,566,111,200.00	1,414,245,450.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,566,111,200.00	1,414,245,450.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,417,895,585.00	1,328,806,320.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,417,895,585.00	1,328,806,320.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,607,945.00	1,129,977,380.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	608,088,000.00	717,571,565.58
210101	Үндсэн цалин	383,136,342.50	434,406,388.38
210102	Нэмэгдэл	199,074,232.50	269,111,505.25
210104	Урамшуулал	25,877,425.00	14,053,671.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,011,000.00	89,819,600.00
210201	Тэтгэврийн даатгал	51,687,400.00	61,077,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,080,900.00	7,185,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,864,700.00	3,592,800.00

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,200.00	3,592,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,161,800.00	14,371,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,000,000.00	48,191,593.00
210301	Гэрэл, цахилгаан	17,000,000.00	25,091,593.00
210302	Түлш, халаалт	40,000,000.00	23,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,777,000.00	54,787,760.00
210401	Бичиг хэрэг	9,000,000.00	7,976,400.00
210402	Тээвэр, шатахуун	26,050,000.00	30,057,896.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	5,659,864.00
210404	Ном, хэвлэл	1,900,000.00	804,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,088,000.00	8,289,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,739,000.00	2,000,000.00
2105	Норматив зардал	1,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,262,800.00	40,764,400.00
210604	Урсгал засвар	37,262,800.00	40,764,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	8,000,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	223,509,145.00	116,993,462.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,109,145.00	116,165,224.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	135,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	143,178.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,460,000.00	53,849,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,460,000.00	53,849,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	262,287,640.00	198,828,939.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,076,110.00	16,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	58,076,110.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	204,211,530.00	182,328,939.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	204,211,530.00	182,328,939.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	155,762,376.00	98,035,893.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	158,628,016.00	103,044,931.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	158,628,016.00	103,044,931.00
2200	Дотоод эх үүсвэрээр	158,628,016.00	103,044,931.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	158,628,016.00	103,044,931.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(158,628,016.00)	(103,044,931.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,865,640.00)	(5,009,038.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	941,091,710.75	1,381,584,841.53

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	941,091,710.75	1,381,584,841.53
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	738,393,211.52	738,393,211.52
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	1,679,484,922.27	2,119,978,053.05
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	1,679,484,922.27	2,119,978,053.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	1,679,484,922.27	2,119,978,053.05
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(31,841,026.11)	(31,841,026.11)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,106,269.20	120,386,861.58	1,647,643,896.16	2,088,137,026.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,539,566,700.00	1,246,466,548.58	293,100,151.42	80.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,443,966,700.00	1,156,121,617.58	287,845,082.42	80.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,427,466,700.00	1,139,621,617.58	287,845,082.42	79.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,556,600.00	717,571,565.58	985,034.42	99.86
210101	Үндсэн цалин	718,556,600.00	434,406,388.38	284,150,211.62	60.46
210102	Нэмэгдэл	-	269,111,505.25	(269,111,505.25)	-
210104	Урамшуулал	-	14,053,671.95	(14,053,671.95)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,819,600.00	89,819,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	61,077,300.00	61,077,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,185,600.00	7,185,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,592,800.00	3,592,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,592,800.00	3,592,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,371,100.00	14,371,100.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,216,800.00	48,191,593.00	35,025,207.00	57.91
210301	Гэрэл, цахилгаан	33,216,800.00	25,091,593.00	8,125,207.00	75.54
210302	Түлш, халаалт	50,000,000.00	23,100,000.00	26,900,000.00	46.20
2104	Хангамж, бараа материалын зардал	63,884,300.00	53,458,600.00	10,425,700.00	83.68
210401	Бичиг хэрэг	10,000,000.00	7,976,400.00	2,023,600.00	79.76
210402	Тээвэр, шатахуун	33,000,000.00	28,728,736.00	4,271,264.00	87.06
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	5,659,864.00	340,136.00	94.33
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	804,000.00	196,000.00	80.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,884,300.00	8,289,600.00	3,594,700.00	69.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	-	100.00

Архангай аймгийн Булган сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	130,984,800.00	46,464,400.00	84,520,400.00	35.47
210602	Тавилга	55,000,000.00	5,700,000.00	49,300,000.00	10.36
210604	Урсгал засвар	75,984,800.00	40,764,400.00	35,220,400.00	53.65
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	8,000,000.00	1,000,000.00	88.89
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,000,000.00	1,000,000.00	88.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,004,600.00	122,266,859.00	139,737,741.00	46.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,909,800.00	121,438,621.00	139,471,179.00	46.54
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	135,060.00	164,940.00	45.02
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	144,800.00	143,178.00	1,622.00	98.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,000,000.00	53,849,000.00	16,151,000.00	76.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,000,000.00	53,849,000.00	16,151,000.00	76.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,500,000.00	16,500,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,500,000.00	16,500,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,500,000.00	16,500,000.00	-	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,600,000.00	90,344,931.00	5,255,069.00	94.50
2200	Дотоод эх үүсвэрээр	95,600,000.00	90,344,931.00	5,255,069.00	94.50
222001	Тоног төхөөрөмж	95,600,000.00	90,344,931.00	5,255,069.00	94.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,537,566,700.00	1,244,466,548.58	293,100,151.42	80.94
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,537,566,700.00	1,244,466,548.58	293,100,151.42	80.94
132001	Орон нутгийн төсвөөс	1,537,566,700.00	1,244,466,548.58	293,100,151.42	80.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(62,314.00)	62,314.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,055,763.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,055,763.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,055,763.00

2104	Хангамж, бараа материалын зардал	1,329,160.00
210402	Тээвэр, шатахуун	1,329,160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,726,603.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,726,603.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,596,763.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,596,763.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,055,763.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,541,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй харин үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй, цалингийн сандаа багтаан бүтцийн өөрчлөлтийг хийгээгүй мөн түлш халаалтын зардлаас 13,100.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **10,776.5** мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд түлш халаалтын зардалд 50,000,000 төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 13,100,000 төгрөгийг ахуйн үйлчилгээний халаалтын зардалд буюу үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын батлагдсан төсвөөс туслах үйл ажиллагаа буюу ахуйн үйлчилгээний халаалтын төлбөрт зарцуулсан 13,100.000 төгрөгийг сумын ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Т.Отгонцэцэг, нярав О.Итгэлмаа нараар гаргуулан орон нутгийн төсвийн орлогын Төрийн сан банкин дахь Ар.Бусад нэр заагдаагүй орлого 100010000955 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой:

Илрүүлэлт: Булган сумын ЗДТГ-ын даргын 2025.12.10-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар "Эд хөрөнгийн болон үндсэн хөрөнгийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" тогтоолоор 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж, эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 7 хоногийн хугацаатай зохион байгуулсан байна. Ажлын хэсэг нь тооллогын явцад хурлын тэмдэглэлийг үйлдэж, баталгаажуулаагүй, эд хариуцагчтай хариуцлагын гэрээ байгуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн

тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, тооллогыг үр дүнтэй зохион байгуулах албан шаардлагыг хүргүүлээ.

5.2.2. Бүтэц, орон тоотой холбоотой:

Илрүүлэлт: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн дагуу цалингийн сандаа багтаан Булган сумын ЗДТГ-ын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д "16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", МУИХ-ын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэсэн чиглэлийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулж, чиг үүргийн давхардлыг арилгах бүтцийн өөрчлөлтийг хийж төсвийг үр ашигтай зарцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

5.1.3. Түлш халаалттай холбоотой:

Илрүүлэлт: Тайлант онд түлш халаалтын зардлаас 13,100.000 төгрөгийн нүүрс худалдан авч ахуй үйлчилгээ болон буудлын байрны галлагаанд зарцуулсан нь арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.2.1-д "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, ахуй үйлчилгээний халаалтын зардлыг түрээслэгчдийн түрээсийн орлогоор шийдвэрлэх албан шаардлагыг хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
тооллогын явцад хурлын тэмдэглэлийг үйлдэж, баталгаажуулаагүй, эд хариуцагчтай хариуцлагын гэрээ байгуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн.	1				1							
ЗДТГ-ын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээ аваагүй.	1				1							
Түлш халаалтын зардлыг үр ашиггүй зарцуулсан	1	13,100.0			1	13,100.0						
Нийт	3	13,100.0			3	13,100.0						